

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРААС  
2020 ОНЫ 05 ДУГААР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2020 оны 06 дугаар сарын 03

Улаанбаатар хот


Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гадаадын болон өөрийн орны иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2020 оны 05 дугаар сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

**НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**

**1.1. Виз, зөвшөөрөл, харьяатын чиглэлээр:**

Тайлант хугацаанд Монгол Улсад оршин суух үнэмлэх 204 ширхгийг шинээр хэвлэн, 649 ширхэг үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 106 ширхэг үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийн, гадаадын дөрвөн иргэнд регистрийн дугаар олгосон байна. Үйлчилгээний танхимаар 624 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэжээ.

Нийт 1367 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгснөөс 1800-1882 дугаарын утсаар 887, 7585-1882 дугаарын утсаар 55, 7013-3459 дугаарын утсаар 10, биечлэн 85, автомат хариулагчаар 330 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Мөн гадаадын гурван орны дөрвөн иргэнд цахим шуудангаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан байна.



Өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан 03 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн хөдөлмөр эрхлэгч, хөрөнгө оруулагч гадаадын иргэдийн Монгол Улсад оршин суух зөвшөөрлийн сунгалтыг цахимаар авч эхэлсэн бөгөөд тайлангийн хугацаанд “Т” ангиллын 18 аж ахуйн нэгж, байгууллагын 22 гадаадын иргэн, “HG” ангиллын 11 аж ахуйн нэгж, байгууллагын 25 гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгалаа. Мөн 05 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн түр ирэгч гадаадын иргэдийн визийн сунгалтын хүсэлтийг цахимаар хүлээн авч эхэлсэн бөгөөд тайлангийн хугацаанд гадаадын гурван иргэний хүсэлтийг шийдвэрлэсэн.

Хилийн зарим боомтыг түр хаах, нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах тухай Засгийн газар, Улсын онцгой комиссын холбогдох тогтоол, шийдвэртэй холбогдуулан Монгол Улсын виз, визийн зөвшөөрөл олголт, Монгол Улсад түр ирэгч болон албан, хувийн хэргээр оршин суух гадаадын иргэний тус байгууллагаас авах үйлчилгээний тоо буурсан үзүүлэлттэй байна.

2020 оны 05 дугаар сарын тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 90.9 хувиар, виз олголт 94.1 хувиар, оршин суух зөвшөөрөл олголт 97.5 хувиар, оршин суух зөвшөөрөл сунгалт 68.2 хувиар, түр ирэгчийн бүртгэл 98.0 хувиар, түр ирэгчийн хасалт 96.9 хувиар тус тус буурсан, харин оршин суух зөвшөөрлийн хасалт 56.9 хувиар, визийн сунгалт 34.5 хувиар тус тус өссөн байна.

Иргэний харьяалал, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын чиглэлээр:


Тайлангийн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэг удаагийн зарлигаар харьяалалгүй нэг хүн Монгол Улсын харьяат болсон бол нэг удаагийн зарлигаар 17 иргэн гадаадын нэг улсын харьяат болохоор Монгол Улсын харьяатаас гарсан байна. Дээрх иргэдийн мэдээлэл болон Ерөнхийлөгчийн зарлигийг Гадаад харилцааны яамны Консулын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яаманд хүргэх ажлыг зохион байгууллаа.

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын нэг улсын хоёр иргэний хүсэлтийг хүлээн авсан ба холбогдох байгууллагаас санал авах ажиллагааг хийж байна.

Монгол Улсын харьяатаас гарч гадаадын хоёр улсын харьяат болох хүсэлт гаргасан 32 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авч, гадаадын хоёр улсын харьяат болох хүсэлт гаргасан 35 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авах ажиллагааг хийж байна. Мөн гадаадын нэг улсын харьяат болох хүсэлт гаргасан гурван иргэний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, нэг улсын харьяат болох хүсэлт гаргасан гурван иргэний хүсэлтийг Ерөнхий сайдад танилцуулснаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлэв.

Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй хоёр хүний хүсэлтийг шинээр хүлээн авч, холбогдох байгууллагаас санал авах ажиллагааг хийж байна. Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй хоёр хүний хүсэлтэд холбогдох

байгууллагаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.



Хоёрдмол харьяалал үүсгэсэн найман иргэнийг шинээр бүртгэж мэдээллийн санд оруулсан ба 2020 оны 05 дугаар сарын байдлаар тус байгууллагын мэдээллийн санд хоёрдмол харьяалал үүсгэсэн 3656 иргэн бүртгэлтэй байна.

Тайлант хугацаанд салбар, төлөөлөгчийн газар шинээр нээн ажиллуулах нэг, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргасан хоёр олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын хүсэлтийг хүлээн авсан.

Мэргэжлийн зөвлөлийн хурлаар олон улсын болон гадаад улсын гурван төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын асуудлыг хэлэлцэн нэг байгууллагад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг шинээр олгож, хоёр байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгалаа. 2020 оны 05 дугаар сарын байдлаар тус байгууллагад бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 90 төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар байна.


## 1.2. Хяналт шалгалт, албадан гаргах ажиллагааны чиглэлээр:

Тайлант хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн гадаадын нэг иргэнийг байгууллагын даргын нэг удаагийн тушаалаар тус улсаас албадан гаргасан ба мэдээллийг холбогдох газруудад албан бичгээр хүргүүлэх ажлыг зохион байгуулав.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр байгууллагын даргын гурван удаагийн тушаалаар гадаадын хоёр улсын дөрвөн иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүллээ.

Гадаадын иргэнийг зохих ангиллын визээр урьж, ажиллуулж байхыг анхааруулан нэг аж ахуйн нэгж байгууллагад хяналтын улсын байцаагчийн албан шаардлага өгсөн.

Тайлант хугацаанд нэг удаагийн төлөвлөгөөт, гурван удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 17 аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын есөн иргэнийг хамруулсан. Түүнчлэн 14 гадаадын иргэн, 38 аж ахуйн нэгж, байгууллага /гадаадын 219 иргэн/, нэг уригч иргэн /гадаадын нэг иргэн/-д Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулж, 62,270,000 /жаран хоёр сая хоёр зуун далан мянга/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүллээ.



2020 оны 05 дугаар сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 88.1 хувиар, зөрчил гаргасан уригч хуулийн этгээд 57.8 хувиар, зөрчил гаргасан уригч иргэн 66.7 хувиар, албадан гаргагдсан гадаадын иргэн 97.4 хувиар тус тус буурсан, харин гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн дөрөв дахин өссөн байна.

## ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, дотоод ажил, хүний нөөц, сургалт, олон нийттэй харилцах чиглэлээр:

Байгууллагын 2020 оны 04 дүгээр сарын үйл ажиллагааны тоон мэдээг инфографик хэлбэрээр гарган Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээ.

Тус байгууллагын зургаан сул орон тооны сонгон шалгаруулалтад албан тушаалын шаардлага хангасан албан хаагч байгаагүй тул “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 2.3.2-т заасны дагуу төрийн жинхэнэ албаны нөөцөд байгаа иргэдээс нөхөх хоёр дахь шатны шалгаруулалтыг нийтэд зарлах санал, Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн чиглэлийн хүрээнд төрийн захиргааны тэргүүн түшмэл, эрхэлсэн түшмэл, ахлах түшмэлийн ангилалд хамаарах нийт 21 албан хаагчийн дэлгэрэнгүй судалгааг тус тус Төрийн албан зөвлөлд хүргүүлсэн.

Төрийн албаны зөвлөлийн удирдах албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтад хамрагдаж тэнцсэн Агаарын замын боомт хариуцсан газрын дарга, Баруун бүс дэх газрын даргыг тус тус томиллоо.

Байгууллагын дэргэдэх хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны хичээлийн жилд хамрагдаж байсан албан хаагчийн 33 хүүхдийн бүртгэлийг шинэчилж, 2021 оны хичээлийн жилд шинээр хамрагдах 24 албан хаагчийн хүүхдийг шинээр бүртгэлээ. Мөн бусад төрийн байгууллагуудаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги - нэгдсэн эмнэлгийн 5 албан хаагчийн 5 хүүхэд, Архивын ерөнхий газрын 4 албан хаагчийн 4 хүүхдийн бүртгэл судалгааг нэгтгэж цэцэрлэгийн захиргаанд хүлээлгэн өгсөн.

Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн нэгдсэн системд байгууллагын төвийн 108 албан хаагч, орон нутаг дахь газрын 146 албан хаагчийн холбогдох мэдээллийг тухай бүр шинэчлэн орууллаа.

Тайваны Боловсролын яамны хятад хэлний тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах албан хаагчдын холбогдох баримт бичгийн бүрдлийг ханган Тайпэйн худалдаа, эдийн засгийн Улаанбаатар дахь төлөөлөгчийн газарт албан бичгээр хүргүүлсэн.

Байгууллагын даргын 2020 оны 01-03/04 дүгээр удирдамжид Агаарын замын боомт хариуцсан газрын албан хаагчдад давтан сургалт, шалгалт зохион байгуулахаар тусгагдсаны дагуу шалгалтыг зохион байгуулж, дүнг танилцуулан ажиллалаа. Мөн байгууллагын 2020 оны сургалтын төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны эрх олгох /АЗ/ эхний ээлжийн сургалтыг “Худалдан авах ажиллагааны хөтөч” төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулав.

Байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлээр 13 мэдээ, мэдээлэл, ярилцлагыг байгууллагын цахим хуудас болон байгууллагын цахим сүлжээгээр олон нийтэд мэдээлэв. Тухайлбал, Захиргаа, удирдлагын газрын даргын байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлээр хийгдсэн дэлгэрэнгүй ярилцлагыг өдөр тутмын “Үндэсний шуудан” сонин, “24tsag.mn”, “asu.mn”, “ikon.mn”, “shuud.mn”, “onttslokh.mn”, “zarig.mn” цахим хуудаст, Виз, зөвшөөрөл, харьяатын газрын ахлах мэргэжилтний гадаадын иргэдийн виз, визийн зөвшөөрөлтэй холбоотой ярилцлагыг өдөр тутмын “Зууны мэдээ” сонин, “gogo.mn”, “arslan.mn”, “ikon.mn”, “livetv.mn”, “24tsag.mn”, “etoim.mn”, “shuud.mn” зэрэг цахим хуудаст нийтэл, олон нийтэд хүргэлээ. Мөн Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизийн “Иргэдийн эрх зүйн боловсролд” нэвтрүүлэгт Виз, зөвшөөрөл, харьяатын газрын хүүхэд үрчлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн оролцсон бөгөөд нэвтрүүлэгт ашиглагдах тоон мэдээлэл, дүрс бичлэгийг нэвтрүүлгийн багт хүргүүлсэн.

Мэдээллийн төвийн 1800-1882 дугаарын утсанд иргэдийн ирүүлсэн түгээмэл асуулт хариултуудыг нэгтгэж англи, монгол хэлээр хоёр цуврал видео бэлтгэж олон нийтэд мэдээллээ.

Байгууллагын үүсэл, хөгжил, үйл ажиллагааны онцлогийг харуулсан түүхчилсэн гэрэл зургийн цомгийг бэлтгэн хэвлүүлэв.

Төв болон орон нутаг дахь газарт нийт 94 өргөдөл, нэг гомдол ирснийг хүлээн авч, бүртгэлжүүлэн харьяалах газар, хэлтэст нь шилжүүлснээс 91 өргөдөл шийдвэрлэгдэж, гурван өргөдөл, нэг гомдол шийдвэрлэлтийн шатандаа байна. Хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдол байхгүй.

“Цасны хачир” ХХК-тай хамтран ажиллах №0044 дугаар гэрээний дагуу гурав дахь удаагийн ариутгал, халдваргүйжүүлэлтийг байгууллагын төв байрны бүх өрөө тасалгаа, цайны газар, спорт заал, автограш, архивын өрөө, хонгилуудад хийлээ.

Улсын онцгой комиссын есдүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх “Амны хаалтаа зүүцгээе” аяны мөрөөр төв болон орон нутаг дахь газруудад хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэхээр ажиллаж байна.

Байгууллагаар үйлчлүүлсэн болон нэвтэрсэн иргэдийг бүртгэж, халууныг хэмжин шаардлагатай тохиолдолд асуумж авч, зөвлөгөө өгөн ажиллаж 05 дугаар сард 1740 иргэн, нийт хугацаанд 4275 иргэд нэвтэрч бүртгүүлснээс биеийн дундаж температур 36.5°C байв.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвтэй хамтран цус хандивлах өдөрлөгийг байгууллагадаа зохион байгуулж төв болон Агаарын замын боомт хариуцсан газрын нийт 35 албан хаагчид сайн дураараа хамрагдаж, цусаа бэлэглэсэн.

## 2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

Зорчигчийн урьдчилсан мэдээллийн дэвшилтэд систем (APP)-ийг Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудалд нэвтрүүлэх тухай Засгийн газрын 2018 оны 306 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх танилцуулгыг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдад албан бичгээр хүргүүлээ.

Тайлант хугацаанд дөрвөн албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулахаар хүргүүлсэн. Мөн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг давхардсан тоогоор 28 албан хаагч гаргасан байна.

“Төрийн албан хаагчийн үүрэг бол ёс зүйн хэм хэмжээг сахиж, нийтийн эрх ашгийн төлөө ажиллах явдал юм” сэдэвт зурагт хуудас, Нийтийн албан тушаалтанд тавигдах 13 төрлийн хориглолт, хязгаарлалтын талаар олон нийтэд болон албан хаагчдад “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй” мэдээллийг тус тус хүргэв.

Байгууллагын төвийн дөрвөн нэгж болон Агаарын замын боомт хариуцсан газрын албан хаагчийн дунд “Албан хаагчдын эрх зүйн мэдлэг шалгах тэмцээн”-ийг гурван үе шаттай зохион байгуулж, мэдлэг, мэдээллээ хуваалцсан үр дүнтэй тэмцээн болсон.

Мөн орон нутаг дахь газрууд болон Хяналт шалгалтын газрын хяналтын улсын байцаагчдад Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн талаар танилцуулгын хийж, хурлын тэмдэглэлийг орон нутаг дахь газруудад цахим шуудангаар хүргүүлэв.

Бүгд Найрамдах Тажикистан Улсын Душанбе хот дахь Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Хилийн менежментийн коллежид зохион байгуулагдах “Хилийн менежмент аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй байгууллагуудын ахлах, дунд түвшний албан хаагчдын 27 дахь удаагийн сургалтад оролцох албан хаагчийн бэлтгэл ажлыг хангаж ажиллав.

Бүгд Найрамдах Казахстан Улсаас Монгол Улсад суугаа Элчин Сайд Ноён Жалгас Адылбаевтай Монгол Улсад буй нутаг буцах боломжгүй байгаа иргэдийн асуудлаар 06 дугаар сард уулзалт зохион байгуулахаар албан ёсоор тохиролцож бэлтгэл ажлыг хангалаа.

Түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллага Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын ахлах мэргэжилтэн Р.Оюунбилэгтэй уулзаж хяналтын улсын байцаагч нарт зориулсан энэ оны сургалтын талаар санал солилцож, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин хотод суугаа Элчин сайдын яамны Зөвлөх, Холбооны Цагдаагийн Албаны төлөөлөгч Дирк Мальцаныг цар тахлын нөхцөл байдал шийдвэрлэгдсэн үед урьж сургалт зохион байгуулахаар хандав.

Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Элчин Сайдын Яаманд тус Улсын холбогдох байгууллагаас хамтран зохион байгуулах мэргэшил дээшлүүлэх сургалтын талаар санал, Хууль зүй, дотоод хэргийн яаманд Японы олон улсын

хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламжаар хэрэгжих төсөл, хөтөлбөрийн санал, байгууллагын гадаад харилцааны нэгдсэн лавлагаа, байгуулсан баримт бичгийн жагсаалтыг тус тус бэлдэж хүргүүлсэн.

### 2.3. Мэдээллийн технологийн чиглэлээр:

“evisa.mn” систем, Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэлтийн программ, өргөдөл гомдлын программд холбогдох хөгжүүлэлтийг хийлээ. Мөн зөөврийн хяналт шалгалтын программ хангамжийн хөгжүүлэлтийг хийж, 0.1 хувилбарыг туршиж байна.

“evisa.mn” системийн сервер рүү гадаад хаягаас маш олон тооны хүсэлт илгээх замаар тус системийн серверийг гацаах, унагах, хэвийн ажиллагааг доголдуулах халдлага гарсан ба үүний эсрэг “evisa.mn” системийг зөвхөн Монгол Улсаас хандах боломжтой болгож, бүх гадаад хаягт хязгаарлалт хийсэн.

Хортой кодын эсрэг 140 ширхэг лиценз, “Microsoft Office программ хангамжийн 30 ширхэг лиценз, “Windows server 2016 AD” нэг ширхэг лиценз, аюулгүй байдлын “cisco firepower” нэг ширхэг лицензийн худалдан авалтыг зохион байгуулж байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Түүнчлэн байгууллагын даргын баталсан удирдамжийн дагуу байгууллагын төвд ашиглагдаж байгаа компьютер, тоног төхөөрөмжийг бүртгэлжүүлэн, үзлэг шалгалтыг хийн, компьютерийн нууц үгийг сольж, шаардлагагүй программ хангамжуудыг устган, албан хаагчдад мэргэжил арга зүйн зөвлөмжийг өгч ажиллав.

### 2.4. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын багцад Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу 2020 онд 7.7 тэрбум төгрөг батлагдсан. 05 дугаар сард 3 тэрбум 353.2 сая төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 2 тэрбум 639.0 сая төгрөгийг зохих дүрэм, журмын дагуу анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Засгийн газрын 2003 оны 172 дугаар тогтоолын дагуу энэ оны 05 дугаар сарын байдлаар 632.1 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 275.7 сая төгрөгийн хүү торгуулийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэн ажиллалаа.

2020 оны 06 дугаар сарын төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах санал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны хөрөнгө оруулалтын төсвийн төслийн санал, 2021 оны урсгал зардлын төсвийн төслийн саналыг албан бичгээр Хууль зүй дотоод хэргийн яаманд тус тус заагдсан хугацаанд хүргүүлсэн.

Байгууллагын төв болон орон нутаг дахь газрын 2021 оны төсвийн төсөл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн саналыг боловсруулан нэгтгэж байна.

2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2020 оны Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, Мэдээлэл, технологийн лиценз, Гадаадын иргэдийн цахим бүртгэл, Дүрэмт хувцасны тендерт шалгарсан аж ахуйн нэгж байгууллагуудтай хийсэн гэрээний дагуу 128.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, гэрээг дүгнэн ажиллаж байна.

### 2.5. Хяналт шинжилгээ, аудитын чиглэлээр:

Байгууллагын 2020 оны 04 дүгээр сарын үндсэн үйл ажиллагааны мэдээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх

газар, Ерөнхий сайдын Ажлын албанд, Гадаадын иргэдийн бүртгэл, хяналтын 2020 оны 04 дүгээр сарын статистик мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус албан бичгээр хүргүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яаманд “Салбарын статистик мэдээллийн сан бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журам”-д өөрчлөлт оруулах саналыг албан бичгээр хүргүүллээ. Мөн байгууллагын 2001-2019 оны Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны статистик эмхэтгэлийг хэвлэн орон нутаг дахь газруудад хүргүүлэв.

Агаарын замын боомт хариуцсан газрын 2019 он, Сэлэнгэ аймаг дахь Хойд бүс дэх газрын 2019 он, 2020 оны нэгдүгээр улирлын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх байгууллагын даргын баталсан удирдамжийн дагуу харилцах, касс, цалин хөлс болон бусад холбогдох анхан шатны баримтын бүрдэл, төсвийн хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгах тухай зөвлөмж, хугацаатай үүрэг өгч ажиллалаа.

#### 2.6. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

Улсын онцгой комиссын 2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 11 дүгээр тогтоол, “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 147 дугаар тогтоол, “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн хэрэгжилтийг тус тус ханган ажиллах үүргийг албан бичгээр орон нутаг дахь газруудад хүргүүлэн, хяналт тавин ажиллаж байна.

Засгийн газрын 2020 оны 147 дугаар тогтоолын дагуу 2020 оны 05 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хилийн боомтоор нэвтрэх зорчигчийн хөдөлгөөнийг түр зогсоосонтой холбогдуулан олон улсын тээвэр гүйцэтгэж байгаа гадаадын иргэн болон тусгай үүргийн нислэгээр ирсэн 12 орны 1915 гадаадын иргэнийг мэдээллийн санд шүүж үзэхэд ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР